

## Хүрийн ногоон нуур

Хүмүүс нуурын ус болон шаварыг хулуу, шар ус, үе мөч, арьсны зарим өвчинд сайн хэмээн нууранд орж шавар, усаар нь сувилан эмчилдэг бөгөөд энэ үеэр нуурын ойролцоох худгийн уснаас уудаг. Тус нууранд галуу, нугас, ангир, тогоруу зэрэг нүүдлийн шувууд ирдэг. Нуурын урт 100м, өргөн 60 радиустай.



## Хаялга нуур

Шивээ -Овоогийн нүүрсний уурхайн гүний усны шавхалтын дүнд үүссэн гүний цэвэр ус бүхий нуур юм. Тус нууранд загас нутагшуулан үржүүлснээр ,бух сугас загасны тодорхой нөөц бий болжээ. Загасны нөөцийг даган усны шувууд ирдэг болсон. Нуурыг түшиглэн аймаг орон нутгаас аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр тодорхой ажлууд төлөвлөгдөн шийдвэрлэх шатанд хэлэлцэгдэж байна.



## Цоорхойн рашаан

Чойрын богд уулнаас баруун тийш уулын хормойд тал газарт Цоорхойн рашаан байдаг. Цоорхойн рашаан зун тасхийм хүйтэн байх атлаа идэр есын хүйтэнд харзлан байдаг ер бусын онцлогтой. Энэхүү рашаан нь хүний дотор эрхтэнд сайн хэмээн нутгийн иргэд амны усандаа хэрэглэж иржээ. Нутгийнхан рашаан хэмээн дээдэлж магнайдаа хүргэн амсдаг нь ариун дагшин байгалиа хайрлаж ирсэн уламжлалтай. Газрын хөрснөөс даруухан цоолдон гарч ундардаг тул цоорхойн рашаан хэмээн нэрлэх болжээ.



## Чойрын богд уул

Чойрын богд уул нь олон зуун жилийн түүхийг хадгалсан байгалийн цогцолбор газар юм. Далайн түвшнээс дээш 1686 м өргөгдсөн боржин чулуудаас тогтсон уул юм. 1923 оноос хайрханы нэрээр хошууг нэрлэж байсан нь түүхэд тэмдэглэгджээ. Оцол гэдэг нь төвд хэлний “Гэгээн гэрэлт” гэсэн үг гэж судлаачид тэмдэглэсэн байх боловч энэ нэр хожуу сангийн судар зохиох үед бий болсон бололтой. Чойрын Богд уулыг 1997 онд орон нутгийн тусгай хамгаалалтанд, 2011 онд байгалийн нөөц газрын ангилалаар улсын тусгай хамгаалалтанд авсан. Одоогоор тус ууланд 200 гаруй аргаль хонь нутагшиж байна. Ховор ургамалын төрөл зүйл ажиглагдахын зэрэгцээ аргаль, янгир, чоно, үнэг, туулай, цармын бүргэд, идлэг шонхор зэрэг ан амьтан элбэгтэй. Чойрын богд уулнаа түүх соёлын давхарга, шашины соёлыг хадгалсан дурсгалууд бий.



### Зүүн чойрын хийдийн туурь

Зүүн чойрын хийд *Жанжин бэйлийн хошууны Зүүн чойр хийдийг Богд уулын “Марзана хоолой Мандлын таван хад” хэмээх энэхүү газарт Тэнгэр тэтгээчийн дөчингуравдугаар (1778) он, XIII жарны шороон нохой жилд Жанжин төрийн ёст мэргэн жонон далай дархан хун тайж, бэйл Дагдандорж ноён байгуулав. Энэ хийдийн түвэд нэр нь “Балдандашгомалин”. тус хошуун дахь бүх шашныг төвлөн захирдаг. Энэ хийд нь Гүнчин игчаны дэгээр гүн ухааны сургалт явуулдаг, буддийн гүн ухааныг судалдаг, анагаах ухаан, цагийн хүрдний онол, тарнийн гүн ухааныг судлах дацангууд бүхий 1500 ламын данстай, хошууныхаа хамгийн том хийд байв. 1853 онд зүүн чойр хийдэд Дүйнхор дацан байгуулагдсан. Зүүн Чойрын хийдэд боржигин Сэцэн вангийн хошууны ноён Цэрэнсандивын урилгаар Гүмбүм хийдээс Сэрдог номун хан Чүлтэмжамц саатан морилж шашины олон ном зохиол туурвисан гэдэг.*



## Цагаан Дарь эх бурхан


Боржигин нутгийн Зүүн Чойрын хийдийн Цогчин дуганы ойролцоох боржин хадны хойш харсан тэгш гадаргуу дээр Цагаан Дарь эх бурханыг / долоон тохой хагас талбайд / 245см өндөр ,170 см өргөн хэмжээтэйгээр урлажээ. Уг бүтээл нь дүрслэлийн хувьд хагас ингэмэл бүтээл юм. Энэхүү бурханд сайн үйлс бүхнээ даатган залбирч идээ ундааны дээжээ өргөн барьдаг уламжлал тогтжээ. **Домог зүйн судалгаа**

Чойрын хийдийн орчимд 1828 онд хижиг өвчин дэлгэрч лам болон энгийн ардын аминд хүрсэн гэдэг.Иймд энэ өвчнийг дарах арга хайсан нутгийн ардууд урт наслуулахын ерөөлт бурхан Цагаан Дарь эхийг Чойр дацангийн дуганы үүд / гол хаалга / чиглүүлэн байрлах боржин хадан дээр бүтээлгэсэнд халуун хижиг өвчин дарагдсан гэх домог өдгөө ам дамжин яригдсаар иржээ.



## Дагвасүндэл бурхан

Бурханы зургийг 317см өндөртэй бүтээсэн бөгөөд бурханд эдүгээ эр хүн айл гэрийн ноён нуруугаа даатган залбирч шүтэж ирсэн эрчүүдийн шүтээн бурхан юм. Дагвасүндэл гэдэг нь нийлмэл бурхан бөгөөд Боржигин Сэцэн вангийн хошууны ноён Цэвдэнгийн үеэс шүтэж ирсэн шүтээн бурхан юм. Бурхны нэр нь **ДАА ЧАГ СОН юм.** Энэ нь Дамдин Чагдар Чунт бурхадын нийлбэр гэсэн үг ажээ. Очирваань бурханы орой дээр Хаянхаярваа бурханы титэм болох морины дүрс байх бөгөөд түүний дээр Чунт бурханы бэлгэдэл хангарьд шувууг дүрслэжээ. УМ БАЗАР ВААНИ ХАЯН ХЯРВАА ГАРУНА ХУМ ПАД гэх тарнийг уг бурханы дүрслэлийн доор бичжээ. Бичвэрийн хэмжээ 220 см,165 см хэмжээтэй,зураасны өргөн нь 15-50 мм юм. Энэхүү бурханыг байгаль дэлхийн барилдлага,таталцал энергийн хуулиар машид зөв бүтээгдсэн учир ноён суудал хийгээд, албан тушаал дэвших, зэрэг цол ахихад машид сайн хэмээн үзэж бүтээгдсэн цагаас өдгөө хүртэл шүтэн золгосоор иржээ.






## Хүүхдийн цагаан овоо

Нутгийнхан энэхүү овоог цагаан овоо гэж нэрлэдэг байснаа хожим нь “Хүүхдийн цагаан овоо” хэмээн нэрийдэж тахиж иржээ. Энэхүү овооноо тахилга хийж хүүхдүүд уралдуулан хувь өгдөг байжээ. Хүүхдийн цагаан овоо нь байгалиас тогтсон овоо хэлбэртэй нэг ширхэг ургаа цагаан чулуу, мөн бөөрөнхий гэр хэлбэртэй нэг ширхэг цайвар боржин чулуунаас бүрдсэн байгалийн овоо юм. Хүний гараар бүтсэн бус байгалийн тогтоцоос бий болсон овоо ажээ. Хүүхдийн цагаан овоонд очихдоо өргөө гэрээ зөгнөн барих, хүүхэд гуйх, хүүхдээ даатган залбирах заншил тогтжээ. Цагаан чулуугаар гэр барих нь угсаатны соёл юм



## Оюун ухааны бэлгэдэл Шарав Арилд

Зүүн Чойрын хийдэд 1899 онд Сэрдог гэгээний сийрүүлсэн “ШАРАВАРИЛД”. Сэцэн бэйл Цэрэнсандив Гүмбэн хийдэд очих үедээ Сэрдог гэгээнд өөрийн хошуунд залах урилга гардуулжээ. 1874 онд 8 дугаар богдыг Амдоод хүрэлцэн ирэхэд Гүмбэнийн Сэрдог гэгээн зэрэг олон ихэс лам нар угтан авч байв. Цэрэнсандив ноён энэ үед заллага айлдсан ажээ. Сэрдог гэгээн Боржигин хошуунд анх ирэхдээ Цэрэнсандив ноёны өргөөнд заларч ноён өөрийн хатан, хүүхдүүдийнхээ хамт Сэрдог гэгээнд шавь орж, манай хошууны Чойрын хуврагуудад номын рашаан хүртээж өгөхийг айлтгажээ. 1899 онд Боржигин ноёны хүсэлтээр 3 дахь удаагаа тус хошуунд морилохдоо энэ хошуунд олон хутагт хувилгаад төрсөн газар учир хойч үе нь оюун ухаанаар баялаг байхыг билгэдэн “Шарав Арилд” ыг хаданд сийрүүлжээ. Өдгөө шалгалт сорилт зэрэгт сайн хэмээн нутгийн олон зорин очих болжээ.



## Гэгээн суварга

Шарав –Арилд сийлсэн хаднаас зүүн хойш ойролцоох элгэн хадны энгэрт наран ургах зүгийг эзлүүлэн сийлсэн нэгэн гэгээн суварга байдаг.Энэ нь 170-100 см хэмжээтэй түүний дэргэд хэд хэдэн тарни бичиж үлдээсэн байна. Монгол нутагт хадны сүг зураг, хүн чулуу,буган чулуу зэрэг тухайн үеийнхээ хүн төрөлхтний соёл, түүхийн гэрч болсон бүтээлүүд олон байдаг. Говьсүмбэр аймгийн нутаг дахь Чойр уулнаа шашины соёлын ул мөрийг хадгалсан олон дурсгалууд бий. Эдгээр дурсгалууд нь өнөөдөр ч олон түмний итгэл үнэмшил, сүсэг бишрэлийг даан хүндлэгдсээр байна. Гэгээн суварга хэмээх энэ бүтээл нь төрийн хар хүн буюу одоогийн төрийн албан хаагч болон бусад ажил албан тушаалыг гэгээн байх, дэвшин дээшлэх тухайд бүтээгдсэн хэмээн үзэж сүсэглэж иржээ.



## Сансар уул

Аймгийн төвөөс зүүн тийш 34 км –т далайн түвшинээс 1682 м өндөр.нутгийнхан энэ уулыг арслангийн хэлбэртэй уул гэдэг бөгөөд уултай холбогдсон домог олон бий. 1700 оноос эхлэн нутгийн ардууд тахидаг байсан ба 1850-иад оноос хошуу ноёны зарлигаар Сансар хайрханыг төр тахиж болжээ. Сансар хайрханыг тахихад уншдаг сан бий. Тахигдаа морь уралдуулан уулын лус савдагийг сэргээж, бөх барилдуулж уулын эзэн шар арслангийн хүч зоригийг бадраана хэмээдэн үздэг ажээ. Шархтай хүн мал гархыг цээрлэж ирсэн уламжлалтай.



## Сүмбэр хайрхан

Энэхүү хайрхан нь хад асга багатай өндөрлөг юм. Аймгийн төвөөс зүүн зүгт 55 км-т далайн түвшнээс 1585 м өндөр.VI-р зууны үеэс эхлэн тахиж ирсэн гэх аман яриа байдаг. 1800 оны эхэн үеэс дан эрчүүд тахиж ирсэн тул эр хүний уул буюу харуул уул, түшмэл уул гэх нь ч бий . Тал хээрийн бүсэд орших ганц хайрхан тул хүний ганц хүүд ээлтэй сайн, нөмөр уул хэмээн үзэж хэдэн зуунаас эрчүүд хаврын тэргүүн ,зуны тэргүүн саруудад тахин морь уралдуулж иржээ. Эртнээс нааш адууны нутаг байсаар ирсэн энэ хайрхан нь зудтай жил ч адуунд ээлтэй нөмөр нөөлөгтэй говийн хайрхан юм. Сүмбэр хайрханыг эр хүн, үрээ морь хоёрын уул ч гэдэг. Сүмбэр хайрханд уяачид гарч хийморио сэргээдэг ёс зан үйл бий.Хайрханы зүүн хойно Уяан товог гэх түүхэн газар ч бий. Хайрханыг тойрон морь уяж, сунгаа хийж наадмын бэлтгэлээ базаадаг морины нутаг ажээ. Сүмбэр хайрханд Боржигины алдарт уяачид ихэд сүслэн шүтэж иржээ. Энэ хайрханы орчмоос Боржигины хурдан хүлгүүд,алдарт уяачид төрөн гарсан байдаг. Сүмбэр хайрханы арын Уяан товог хэмээх газар Морин Спорт уяачдын холбооноос дурсгалын хөшөөг 2011 онд босгожээ.



## Даллагын хад

Даллагын хад нь түргийн үеийн соёлын давхарга бүхий буга, болон ан амьтны дүрслэлийг хадгалсан байдаг. */Дүрслэл нь маш бүдэг үлджээ/* Тэнгэр хангайгаа шүтэх соёлын эртний ул мөрийг хадгалсан энэ хүү хаднаа зөн олон идээ цайны дээжээ өргөн, даллагын уут болон цагаан хурганы арьсаар даллага авч ёслох болжээ. Энэ нь тэгш сайхан явах, мал сүрэг бүрэн мэнд байхыг хүсэмжлэн тэнгэртээ даатгаж буй эртний зан үйлийн улбаа юм. Өдгөө нутгийн олон тэнгэрийн хад ч гэж нэрлэх нь бий.





## Зараагийн зүүн өвөрийн хүн чулуу

Аймгийн төвөөс зүүн тийш 25 орчим км, Бага Сансар уулаас баруун хойш 10-аад км-т оршино. Энэхүү дурсгал нь ерөнхий шинж байдал ,бүтцээрээ Түрэгийн үеийн тахилга шүтээний дурсгалын шинж чанарыг агуулсан боловч урьд өмнө нь тохиолдож байгаагүй онцлог шинжүүдтэйгээрээ судлаачдын сонирхлыг татсаар байдаг. **Судлагдсан байдал:** 1988 онд зөвлөлтийн эрдэмтэн В.Е. Войтов, археологич Д. Баяр нар анх илрүүлж улмаар 1998 онд Г.Гонгоржав, Г.Энхбат нар лавшруулан судалсан бөгөөд 2008 оноос Говьсүмбэр аймгийн музей албан ёсоор судалгааны эргэлтэд оруулан нийтэд хүргэж байна. **Дүрслэлийн тухай:** Энэ нь маш урт гонзгой чулууны дээд хэсгийг засаж мөлийлгөн хүний толгой болон 2 гарын дүрс гаргаж хийсэн болхидуу хийцтэй хөшөө ажээ. Дүрслэхдээ нумарсан урт хөмсөгтэй,хөмсөгний урдаас хамрыг залган үргэлжлүүлж хоёр самсааг тодорхойгаргасан байдаг. Урт гонзгой нүүртэй,зузаан уруултай бөгөөд бүх дүрслэлээ хонхор зураасаар гаргажээ.



## Төмөр утасны хорооны туурь

Чойрын уулын зүүн өмнөд хэсэгт энэхүү туурь бий.Үүнийг төмөр утасны хорооны туурь гэх боловч тухайн үедээ уг барилгаас гадна газар доор зоорь хэлбэртэй баригдсан хэд хэдэн байгууламж байсан гэдэг. Хаант Орос Манж Хятадын хооронд улс төр ,эдийн засаг,худалдаа наймааны олон талын харилцаа Ар Монголын нутгаар дамжин хэрэгжиж байсан ба 2 орны харилцааг шуурхай найдвартай болгох нь тэдэнд стратегийн ач холбогдолтой байжээ. 1892 онд Орос Манжийн хооронд байгуулсан гэрээ ёсоор Бээжин Эрхүүг холбосон телеграфийн холбоог 1899 онд Их хүрээнд цахилгаан мэдээний газар байгуулсаны дараа **1906 онд Чойрын төмөр утасны хороо** байгуулагджээ. Энд оросын мэргэжилтэн Кузнецов, монгол ажилтан Бадарч нар ажиллаж байв.



Чойрын хүн чулуу

Говьсүмбэр аймгийн төвөөс 15км орчимд байх Сансар хайрханы орчмоос 1928 онд олдсон түргийн үеийн дурсгал болох Чойрын хүн чулуу нь одоогоор Монголын Үндэсний Түүхийн музейд “Чойрын хүн чулуу” – нэрээр хадгалагдаж байна. Энэ хүү дурсгал нь 700 - 715 оны үед холбогдох юм хэмээн эрдэмтэд таамагладаг. Эртний Түрэгийн рүни бичгээр 72 ширхэг үсэг сийлж, янгир дүрст 2-3 тамга дүрслэжээ. Түрэг судлаач эрдэмтдийн анхаарлыг татсаар ирсэн бичигт хүн чулууны бичээсийг анх тайлан унших оролдлого хийсэн судлаач бол Монголын эрдэмтэн Б.Ренчин нар юм.

Чулуу – боржин

Өндөр – 132см

Өргөн – 45 см Хөндлөн – 22см



Уулзварын гол

Чойрын богд уулын ар гэзгээр баруун зүгт урсах голыг уулзварын гол гэнэ. Энэхүү гол нь нэлээд ширүүн урсгалтай өргөн гол байсныг гэрчлэх нэгэн гүүрний туурь одоо ч судлаачдын анхаарлыг татдаг. Гүүрийг чулуу шавар зэргээр барьж байгуулсан нь нэлээд эрт баригдсан гүүр болохыг гэрчилдэг. Энэ хүү голд хуртай жил дун элбэг байдаг.

